

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/247/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Шинжээч Т.Майцэцэг

Утас: 70273465 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УЕПГ	Улсын ерөнхий Прокурорын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.01.20 № 01/Н1
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОР ХУУЛЬ ЦААЗЫН
ШАДАР ЗӨВЛӨХ М.БУЯННЭМЭХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Прокурорын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Прокурорын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан байна. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн ба гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх санамж, гарын авлага мэдээллийг иргэдэд хүртээмжтэй, ашиглахад хялбар болгох зорилгоор QR кодоор нэвтэрч цахим хэлбэрээр мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн нь шинэлэг ажил болсон байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласнаар нийт 21,875.3 мянган төгрөгийн зардлыг хэмнэлттэй зарцуулж, төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

019000045

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,743,940.00	34,549,540.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,575,600.00	11,575,600.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	11,575,600.00	11,575,600.00
3121	Төгрөг	11,575,600.00	11,575,600.00
31213	Арилжааны банк дахь харилцах	11,575,600.00	11,575,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	21,168,340.00	22,973,940.00
354	Хангамжийн материал	21,168,340.00	22,973,940.00
35420	Аж ахуйн материал	1,698,500.00	2,228,500.00
35450	Барилгын засварын материал	6,729,000.00	3,165,500.00
35470	Бусад хангамжийн материал	12,740,840.00	17,579,940.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	581,802,696.52	533,375,800.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	581,802,696.52	533,375,800.39
392	Биет хөрөнгө	532,587,696.52	484,545,800.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	311,104,510.00	311,104,510.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,339,163.59	-25,786,289.31
39203	Авто-тээврийн хэрэгсэл	97,228,570.00	97,228,570.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-26,705,357.15	-51,364,285.61
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	150,013,270.36	159,834,400.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	-40,095,467.44	-70,115,188.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	77,944,444.63	102,544,444.63
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,563,110.29	-40,900,360.82
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,000,000.00	3,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-999,999.96
393	Биет бус хөрөнгө	49,215,000.00	48,830,000.04
39301	Програм хангамж	1,540,000.00	1,540,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-384,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	47,675,000.00	47,675,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	614,546,636.52	567,925,340.39
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,575,600.00	11,575,600.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,575,600.00	11,575,600.00
414	Урьдчилж орсон орлого	11,575,600.00	11,575,600.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	11,575,600.00	11,575,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	602,971,036.52	556,349,740.39
51	Засгийн газрын хувь оролцоо	602,971,036.52	556,349,740.39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	254,549,065.00	254,549,065.00
51101	Өмч: - төрийн	254,549,065.00	254,549,065.00
512	Хуримтлагдсан үр дүн	187,204,076.16	140,582,780.03
51210	Өмнөх үеийн үр дүн	187,204,076.16	179,281,063.26
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-38,698,283.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	161,217,895.36	161,217,895.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	614,546,636.52	567,925,340.39

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,165,411,550.00	1,217,908,630.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	69,268,050.00	9,821,130.00
120	Нийтлэг татварын бус орлого	69,268,050.00	9,821,130.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,096,143,500.00	1,208,087,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,096,143,500.00	1,203,087,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,096,143,500.00	1,203,087,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,134,769,292.89	1,256,606,913.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,125,352,626.20	1,256,606,913.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,031,152,668.40	1,252,356,913.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	788,348,618.00	930,424,451.00
210101	Үндсэн цалин	472,680,772.00	515,646,498.00
210102	Нэмэгдэл	247,332,218.00	271,822,434.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,845,000.00	43,655,000.00
210104	Урамшуулал	34,490,628.00	99,300,519.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,460,975.00	113,945,501.67
210201	Тэтгэврийн даатгал	66,013,341.93	77,737,857.48
210202	Тэтгэмжийн даатгал	7,766,276.18	9,142,650.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,102,141.01	7,217,324.47
210204	Ажилгүйдлийн даатгал	1,507,201.02	1,804,331.16
210205	Эрүүл мэндийн даатгал	15,072,014.86	18,043,338.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,348,823.00	40,934,141.04
210301	Гэрэл, цахилгаан	3,683,894.00	5,866,149.24
210302	Түлш, халаалт	27,764,825.00	32,626,381.80
210303	Цэвэр, бохир ус	3,900,104.00	2,441,610.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,857,996.20	32,304,375.35
210401	Бичиг хэрэг	10,413,470.00	10,757,560.00
210402	Тээвэр, шатахуун	13,835,019.20	13,635,317.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,681,997.00	3,981,328.35
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	792,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,135,510.00	3,690,170.00
2105	Нормативт зардал	1,279,100.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,279,100.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,264,690.00	14,350,780.00
210604	Урсгал засвар	8,264,690.00	14,350,780.00
2107	Томилолт, зочны зардал	7,348,000.00	9,714,000.00
210702	Дотоод албан томилолт	7,348,000.00	9,714,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,553,050.00	5,756,392.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,679,950.00	4,872,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	235,000.00	281,798.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	140,100.00	148,594.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,691,416.20	83,052,013.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,806,300.00	8,127,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,885,116.20	74,925,013.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,199,957.80	26,125,258.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,150,000.00	4,250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,150,000.00	4,250,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	92,049,957.80	21,875,258.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	92,049,957.80	21,875,258.94
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,416,666.69	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,416,666.69	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	30,642,257.11	-38,698,283.23
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	30,642,257.11	-38,698,283.23

2.АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,102,143,500.00	1,208,087,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,000,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,000,000.00	00.00
120009	Бусад орлого	6,000,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,096,143,500.00	1,208,087,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,096,143,500.00	1,203,087,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,096,143,500.00	1,203,087,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
2	НИЙТ ЗАРПАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,083,162,000.00	1,183,487,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,083,162,000.00	1,183,487,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	981,962,042.20	1,179,237,500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	788,348,618.00	930,424,451.00
210101	Үндсэн цалин	472,680,772.00	515,646,498.00
210102	Нэмэгдэл	247,332,218.00	271,822,434.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,845,000.00	43,655,000.00
210104	Урамшуулал	34,490,628.00	99,300,519.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,460,975.00	113,945,501.67
210201	Тэтгэврийн даатгал	66,013,341.93	77,737,857.48
210202	Тэтгэмжийн даатгал	7,766,276.18	9,142,650.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,102,141.01	7,217,324.47
210204	Ажилгүйдлийн даатгал	1,507,201.02	1,804,331.16
210205	Эрүүл мэндийн даатгал	15,072,014.86	18,043,338.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,348,823.00	40,934,141.04
210301	Гэрэл, цахилгаан	3,683,894.00	5,866,149.24
210302	Түлш, халаалт	27,764,825.00	32,626,381.80
210303	Цэвэр, бохир ус	3,900,104.00	2,441,610.00

2104	Хангамж, бараа материалын зардал	32,592,467.20	35,672,925.35
210401	Бичиг хэрэг	10,413,470.00	10,757,560.00
210402	Тээвэр, шатахуун	12,056,000.20	11,804,767.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,681,997.00	3,981,328.35
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	337,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,104,000.00	8,889,270.00
2105	Нормативт зардал	1,493,600.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,493,600.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,925,690.00	10,772,280.00
210604	Урсгал засвар	7,925,690.00	10,772,280.00
2107	Томилолт, зочны зардал	5,362,000.00	7,098,000.00
210702	Дотоод албан томилолт	5,362,000.00	7,098,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,243,069.00	10,387,942.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,369,969.00	9,503,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	235,000.00	281,798.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	140,100.00	148,594.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,186,800.00	30,002,258.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,186,800.00	8,127,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101,199,957.80	4,250,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	7,000,000.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	7,000,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,150,000.00	4,250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,150,000.00	4,250,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	92,049,957.80	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	92,049,957.80	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	18,981,500.00	24,600,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,981,500.00	24,600,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,981,500.00	24,600,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,981,500.00	24,600,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,981,500.00	24,600,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-19,981,500.00	-24,600,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-1,000,000.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,575,600.00	11,575,600.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,575,600.00	11,575,600.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	254,549,065.00	161,217,895.36	156,561,819.05	00.00	572,328,779.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,549,065.00	161,217,895.36	156,561,819.05	00.00	572,328,779.41
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	30,642,257.11	00.00	30,642,257.11
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,549,065.00	161,217,895.36	187,204,076.16	00.00	602,971,036.52
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	254,549,065.00	161,217,895.36	187,204,076.16	00.00	602,971,036.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-7,923,012.90	00.00	-7,923,012.90
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,549,065.00	161,217,895.36	179,281,063.26	00.00	595,048,023.62
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-38,698,283.23	00.00	-38,698,283.23
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,549,065.00	161,217,895.36	140,582,780.03	00.00	556,349,740.39

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,203,087,500.00	1,181,212,241.06	21,875,258.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,203,087,500.00	1,181,212,241.06	21,875,258.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,198,287,500.00	1,176,962,241.06	21,325,258.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	937,255,100.00	930,424,451.00	6,830,649.00
210101	Үндсэн цалин	536,100,400.00	515,646,498.00	20,453,902.00
210102	Нэмэгдэл	345,749,900.00	271,822,434.00	73,927,466.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,704,000.00	43,655,000.00	-2,951,000.00
210104	Урамшуулал	14,700,800.00	99,300,519.00	-84,599,719.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,156,900.00	113,945,501.67	3,211,398.33
210201	Тэтгэврийн даатгал	79,984,900.00	77,737,857.48	2,247,042.52
210202	Тэтгэмжийн даатгал	9,293,000.00	9,142,650.03	150,349.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,434,400.00	7,217,324.47	217,075.53
210204	Ажилгүйдлийн даатгал	1,858,600.00	1,804,331.16	54,268.84
210205	Эрүүл мэндийн даатгал	18,586,000.00	18,043,338.53	542,661.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,370,600.00	40,934,141.04	1,436,458.96
210301	Гэрэл, цахилгаан	6,864,800.00	5,866,149.24	998,650.76
210302	Түлш, халаалт	32,166,000.00	32,626,381.80	-460,381.80
210303	Цэвэр, бохир ус	3,339,800.00	2,441,610.00	898,190.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,545,500.00	35,672,925.35	2,872,574.65
210401	Бичиг хэрэг	10,960,000.00	10,757,560.00	202,440.00
210402	Тээвэр, шатахуун	12,063,500.00	11,804,767.00	258,733.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,982,000.00	3,981,328.35	2,000,671.65
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ари	240,000.00	240,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,300,000.00	8,889,270.00	410,730.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,554,000.00	30,372,280.00	181,720.00
210602	Тавилга	19,600,000.00	19,600,000.00	00.00
210604	Урсгал засвар	10,954,000.00	10,772,280.00	181,720.00
2107	Томилолт, зочны зардал	13,100,000.00	7,098,000.00	6,002,000.00
210702	Дотоод албан томилолт	13,100,000.00	7,098,000.00	6,002,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, х	11,178,400.00	10,387,942.00	790,458.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	10,250,000.00	9,503,550.00	746,450.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	281,800.00	281,798.00	02.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	22,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	148,600.00	148,594.00	06.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8127000.00	8127000.00	00.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,127,000.00	8,127,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,800,000.00	4,250,000.00	550,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,800,000.00	4,250,000.00	550,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,203,087,500.00	1,181,212,241.06	21,875,258.94
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,203,087,500.00	1,181,212,241.06	21,875,258.94
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,203,087,500.00	1,181,212,241.06	21,875,258.94
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	11,575,600.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	11,575,600.00	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	5,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		5,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		5,000,000.00
210602	Тавилга		5,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	5000000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Прокурорын газар нь эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулан, хүний эрх, эрх чөлөө, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж, зөрчигдсэн эрхийг сэргээн, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцдог чиг үүрэг бүхий Улсын ерөнхий Прокурорын газарт санхүүгийн тайлангаа нэгтгэдэг Хууль зүйн яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналт, зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих хяналт, ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт, шүүхэд төрийн төлөөлөх хяналтын үйл ажиллагаа явуулдаг байна.

Төв аймгийн Прокурорын газар нь Прокурорын байгууллагын 2023 онд дэвшүүлсэн зорилт, Монгол Улсын Ерөнхий прокурорын 2019 оны 04, 05, 06, 07, 2020 оны 03 дугаартай албан даалгавар, прокурорын байгууллагын Удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөнөөс өгсөн үүргийг хэрэгжүүлж, 2022 оны хийсэн ажилдаа дүн шинжилгээ хийж, хэрэгжүүлэх асуудлуудыг тодорхойлон 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө 6 зорилт, 116 ажил хийж гүйцэтгэхээр тусгасан төлөвлөгөөгөө 100 хувь биелүүлсэн байна.

Төв аймгийн Прокурорын газар нь нэгдмэл төвлөрсөн удирдлагатай ба тайлант онд аймгийн ерөнхий прокурор 1, орлогч прокурор 1, ахлах прокурор 3, хяналтын прокурор 11, Тамгын хэлтсийн дарга 1, прокурорын туслах ажилтан 4, үйлчилгээний ажилтан 11 бүгд 32 орон тоотой батлагдсанаас, гүйцэтгэлээр зарим саруудад 1-3 орон тоо дутуу ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Прокурорын байгууллага нь 2023-2026 оны стратеги төлөвлөгөөг Төрийн албаны тухай хууль, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдийг үндэс суурь болгон боловсруулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, гадаад, дотоод орчны хурдацтай өөрчлөлт нь прокурорын байгууллагын үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах хэрэгцээг бий болгож байна. Мөн гадаад, дотоод болон олон улсын байгууллагатай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг сайжруулахаар ажиллаж байна.

Төв аймгийн Прокурорын газар нь үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Прокурорын тухай хууль зэрэг хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

Улсын ерөнхий Прокурорын газрын Дотоод аюулгүй байдал хяналт шалгалтын хэлтсээс дотоод аудитын үйл ажиллагааг удирдан явуулдаг, дотоод аудитор 1 орон тоотой ажилладаг ба тус газарт 2023 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Аймгийн Прокурорын газар нь 2023 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлж ажлын хүрээнд өмнөх оны гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж, судалгааны дүнг олон нийтэд мэдээлэл хүргэх танилцуулга сэтгүүлийг гаргаж, аймгийн төр захиргааны байгууллага болон 27 сумын удирдлагад хүргүүлэн ажилласан. Уг гарын авлага мэдээллийг иргэдэд хүртээмжтэй, ашиглахад хялбар болгох зорилгоор QR кодоор нэвтэрч цахим хэлбэрээр мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн, видео бичлэгээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэсэн нь шинэлэг ажил болсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Прокурорын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Улсын ерөнхий Прокурорын 2021 оны 12 дугаар сарын 16-ны А/179 дугаар тушаалаар батлагдсан шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Прокурорын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46,621.3 мянган төгрөгөөр буюу 7,6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	11,575.6	11,575.6	0.0
Бараа материал	21,168.3	22,973.9	1,805.6
Үндсэн хөрөнгө	581,802.7	533,375.8	-48,426.9
Нийт хөрөнгө	614,546.6	567,925.3	-46,621.3
Өр төлбөр	11,575.6	11,575.6	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	602,971.0	556,349.7	-46,621.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	614,546.6	567,925.3	-46,621.3

Дээрх хүснэгтээс харахад бараа материал дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гараагүй.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 533,375.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 48,426.9 мянган төгрөгөөр буурсан. Энэ нь Монгол Улсын Ерөнхий прокурорын А/52 дугаар

тушаалын дагуу 9,821.1 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг балансаас балансад, урсгал төсвийн 19,600.0 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-ын дэмжлэгээр 5,000.0 мянган төгрөгийн хөрөнгө шинээр бэлтгэж, тайлант хугацаанд 74,925.0 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийн зардал тооцоноос шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 556,349.7 мянган төгрөг болж 46,621.3 мянган төгрөгөөр буурсан нь завсрын аудитаар зарим хөрөнгийн элэгдлийн зардлыг зөрүүтэй тооцоолсон байсныг залруулах зөвлөмж өгөгдсөн дагуу 7,923.0 мянган төгрөгийг өмнөх үеийн үр дүнд бичилт хийсэн болон тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,160,774.2 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого байхгүй, нийт зарлагыг 1,160,774.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Прокурорын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 94,690.7 мянган төгрөгөөр бууруулан Монгол Улсын Ерөнхий прокурорын 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/133 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар 2023 оны урсгал зардлын төсвийг 1,066,083.5 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд тодотгол орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэх зорилгоор 2023 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн Монгол Улсын Ерөнхий прокурорын А/139 тушаалаар 1,203,087.5 мянган төгрөг болгон тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 1,066,083.5 мянган төгрөгийг 137,004.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг прокурорын хяналт хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,203,087.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, үйл ажиллагааныхаа зардалд зарцуулан, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 21,875.3 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,181,212.2 мянган төгрөг буюу 98,2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 21,875.3 мянган төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70703/80101 үндсэн үйл ажиллагаа	1,188,287.5	1,167,675.6	20,611.9	98.3
2	70703/82315 гэмт хэргээс урьдчилан сэргийлэх байцаан шийтгэх ажиллагаа	10,000.0	9,286.6	713.4	92.9
3	70703/80802 ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	4,800.0	4,250.0	550.0	88.5
	ДҮН	1,203,087.5	1,181,212.2	21,875.3	98.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Прокурорын газар нь нэмэлт санхүүжилтийн дансандаа 2023 онд Төв аймгийн ЗДТГ-аас олгосон 5,000.0 мянган төгрөгийн дэмжлэгийг төвлөрүүлж, тавилга эд хогшил бэлтгэсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт нэг хөтөлбөрийн гурван арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	/мянган төгрөгөөр/		
				Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70703	2023.01.01-2023.12.31	Прокурорын хяналт	Хөтөлбөр 98,2 %	1,203,087.5	1,181,212.2

Төв аймгийн Прокурорын газар нь төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласнаар нийт 21,875.3 мянган төгрөгийн зардлыг хэмнэлттэй зарцуулсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлсөн байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Прокурорын газар нь 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу бичиг хэргийн материал 10,757.5 мянган төгрөг, тээвэр шатахуун 11,804.7 мянган төгрөг, урсгал засварын зардалд 10,772.3 мянган төгрөг, бараа материал, цэвэрлэгээний материал 8,889.3 мянган төгрөг, ГХУС зардалд 9,503.5 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 3,981.3 мянган төгрөг, хог хаягдлын зардалд 240.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 8,127.0 мянган төгрөг бүгд 64,075.6 мянган төгрөгөөр харилцагч байгууллагуудтай худалдан авах гэрээг байгуулан шууд худалдан авалт хийсэн байна.

Худалдан авах бараа ажил үйлчилгээ цахим дэлгүүрт байршаагүй, үнэ өндөр зэргээс шалтгаалан цахим худалдан авалт хийгээгүй, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохих зөвшөөрөл авч шууд худалдан авалтуудыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Прокурорын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг гэрээт шинжээч Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Прокурорын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/129 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүү үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 1,158,262.9 мянган төгрөгийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 17,373.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13,030.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг жилийн эцсийн санхүү үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,256,606.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 18,84.1 мянган төгрөгөөр дахин шинэчлэн тогтоосон. Энэ нь төлөвлөх үе шатанд тогтоосон дүнгээс материаллаг байдал 1,475.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал 1,106.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласнаар цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 10,042.0 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 1,436.5 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 202.4 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 6,002.0 мянган төгрөгөөр, бусад түүхий эд материал, урсгал засвар, бараа үйлчилгээний зардлыг 4,192.4 мянган төгрөгөөр буюу нийт 21,875.3 мянган төгрөгийн зардлыг хэмнэлттэй зарцуулж, төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Прокурорын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансанд байршуулах 159 мэдээллийг бүрэн байршуулж, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 орлогын, 3 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө хөрөнгө зарцуулах 20 шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Прокурорын газрын эхний 9 сарын байдлаарх санхүүгийн тайлан, баримтад завсрын аудит хийгдэж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгөгдсөн. Зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 11-ны өдөр ирүүлсэн.

Тус газар нь завсрын аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн тул аудитын тайланд тусгах шаардлагагүй гэж үзлээ. Үүнд:

1. Байгууллагын авто тээврийн хэрэгслийн 351.2 мянган төгрөгийн татвар, замын хураамж, агаарын бохирдол, бусад он дамжсан өр, төлбөр, хураамжийг төлж барагдуулсан.

2. 2023 оны эхний 9 сард нэмэгдсэн 34.388.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Үндсэн хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх баримт НХМаягт ҮХ-1 маягтыг хөрөнгө хүлээн авсан өдрөөр № 1-5 ийг асуултын дагуу бөглөж байгууллагын дарга, захирлаар батлуулан тооллогын баримтад хавсарган зөвлөмжийг биелүүлсэн.

3. Тус газрын барилга байгууламж дансанд бүртгэлтэй 2 орон сууц, конторын барилга, гражийн элэгдэл бүгд 4,560.5 мянган төгрөг, дастер маркийн автомашины элэгдэл 3,362.5 мянган төгрөг нийт 7,923.0 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг нягтлан бодох бүртгэлийн программ алдаатай тооцоолж дутуу бодогдсон байсныг залруулан өмнөх оны үр дүнд бичилт хийсэн.

4. Монгол шуудан ХХК-тай холбоотой 948.0 мянган төгрөгийн төлбөрийн баримтыг автоматаар төлбөрийн баримт үүсэх байсан боловч программын алдаанаас болж татагдаагүй байсныг 10, 11 сард нөхөж оруулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Прокурорын газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,875.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн уялдааг шалгахад үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийн орлого, мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардлаас 5,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд төсөвт буцаан төвлөрүүлсэн 21,875.3 мянган төгрөгийг тохируулга хийгээгүй, нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланг тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлагналтай холбоотой алдаа	2	26,875.3			2	26,875.3	2	26,875.3				
Дүн	2	26,875.3			2	26,875.3	2	26,875.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	0	0.0					0	0.0				
Дүн		0.0					0	0.0				